



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Гэрээт аудитор:	М.Дүүрэнжаргал
		Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

МАН. О.А. ОО № *16/67*

танай _____ -ны № _____ -т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.БААСАНЖАВ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанширээ сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт		2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	34.4	64.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,781.7	1,752.6
	Нийт хөрөнгийн дүн	1,816.1	1,816.6
	Нийт өр төлбөрийн дүн	-	0.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,816.1	1,816.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,816.1	1,816.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	851.3	624.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	450.9	600.3
	Үйл ажиллагааны үр дүн	400.4	23.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	24.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	400.4	-0.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	4.2	-0.2
	Эцсийн үлдэгдэл	1,816.2	1,816.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	554.0	362.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	345.4	358.0
	Үйл ажиллагааны ЦМГ	208.6	4.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-4.9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	280.6	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	312.5	339.1
	Урсгал зардал	312.5	339.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	312.5	339.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	311.7	333.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.8	5.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах үйл ажиллагааг эрхэлнэ. Засаг даргын дэргэдэх тасаг, албад нь Тамгын газраас боловсруулж, Засаг даргын шийдвэрлэсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээнэ.

Тамгын газар нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажиллана. Сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, төрийн захиргааны албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтод тус тус тусгаж хэрэгжүүлнэ.

2021 онд иргэдийн амар тайван аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, ажилгүйдэл ядуурлын түвшинг бууруулан, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг цогцлоон төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг төгөлдөршүүлж, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд өссөн үндэсний тэргүүлэгч сум болно гэсэн зорилгыг тавьж ажилласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллага нь 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдөр ВҮС ХХК-аас 3.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий өвсийг, Дундговь аймгийн отрын айл Жаргалсайханы гэр бүлээс 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 1.4 сая төгрөгийн 4 төрлийн 22 толгой малыг хандиваар хүлээн авсан байна. Мөн Өвөрхангай аймгийн Хөдөө аж ахуйн газраас 5.0 сая төгрөгийг отроор өвөлжиж буй малчдад тусламж үзүүлэх зорилгоор нэмэлт данс руу шилжүүлсэн. Дээрх хандивыг хүлээн авахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 290.5 сая төгрөгийн 19 орлогын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 59.9 сая төгрөгийн 71 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21.3 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээг, 40.7 сая төгрөгийн 44 тушаалыг огт байршуулаагүй байна. Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ковид-19 цар тахалтай холбоотой дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй хандив, тусламж хүлээн авч, зарцуулсан байх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 15.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.7 сая төгрөгийн алдааг залруулж, 9.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 0.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

1. Үндсэн хөрөнгийн журналаас зарлагын гүйлгээг шүүж, эрх бүхий байгууллагын шийдвэртэй тулгаж үзэхэд 0.4 сая төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил данснаас илүү акталсан, авто тээврийн хэрэгсэл данснаас 2.1 сая төгрөгийн мотоцикль хаяа хөрөнгийг илүү акталсан байна. Тус алдааг аудитын явцад залруулав.
2. Ерөнхий журналыг зардал тус бүрээр шүүж үзэхэд нийт 0.3 сая төгрөгийн 8 гүйлгээг буруу зардалд тайлагнасан байна. Тус алдааг аудитын явцад залруулав.
3. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналыг санхүүгийн тайлангийн хуримтлагдсан элэгдлийн дүнтэй тулгахад авто-тээврийн хэрэгсэл данс 0.3 сая төгрөгөөр, тавилга, аж ахуйн эд хогшил данс 0.02 сая төгрөгөөр, программ хангамж данс 1.5 сая төгрөгийн зөрүү үүссэн байна. Тус алдааг аудитын явцад залруулав.
4. Ерөнхий журналаас биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнг шүүж үзэхэд 4.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан бөгөөд үндсэн хөрөнгийн тайланд худалдан авсан хөрөнгө 5.0 сая төгрөгөөр тусгагдсан байсныг аудитын явцад залруулсан.
5. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс элэгдлийн дүн сөрөг утгатай хөрөнгийг шүүж үзэхэд 2.3 сая төгрөгийн 5 төрлийн хөрөнгө илэрсэн бөгөөд үлдэгдэл өртөг нь (0.1) сая төгрөг байсныг аудитын явцад залруулав.

Зөвлөмж:

1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 06 дугаар “эд хөрөнгийг акталж, данснаас хасах, балансаас балансад шилжүүлэх, худалдах тухай” тогтоолоор батлагдсан 27 нэр төрлийн 22.2 сая төгрөгийн 49 ширхэг хөрөнгийг устгасан боловч хөрөнгө устгалын акт үйлдэж, баталгаажуулаагүй.
2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 дансны 222.3 сая төгрөгийн 231 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Албан шаардлага:

1. Хөрөнгө зарцуулах 60.0 сая төгрөгийн 71 тушаал, шийдвэр гарсан. Үүнээс 40.7 сая төгрөгийн 44 тушаал огт байршуулаагүй байна. Хөрөнгө зарцуулах тушаал шийдвэрийг шилэн дансанд мэдээлсэн байдал 17 хувьтай байна. Нийт шилэн дансанд оруулсан мэдээллээс 9 мэдээлэл хугацаа хоцорсон байна.
2. Бараа материалын орлогын дэлгэрэнгүй журналыг шүүж үзэхэд 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ВҮС ХХК-аас 3.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий өвсийг хандивласан байхыг нягтлан бодогчоос тодруулсан. Дундговь аймгийн иргэдээс 1.5 сая төгрөгийн 4 төрлийн 22 толгой малыг малчдад хандивласан. Мөн Өвөрхангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас отрын малчдад дэмжлэг үзүүлэх нэртэйгээр 5.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулж, зарцуулсан.

Төлбөрийн акт:

1. Д.Зоригтбаатар жолоочид 2021 оны 1,2 дугаар сард мэргэшлийн зэргийн нэмэгдэл гэх 0.2 сая төгрөгийг илүү олгосон болно.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	10	15.4	5	5.7	1	0.2	2	9.5	2	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	10	15.4	5	5.7	1	0.2	2	9.5	2	-